



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар Б/27

Ховд

Түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.4, Засгийн газрын 2019 оны 09 дүгээр тогтоолын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Мөнхжагаа нь жирэмсний болон амаржсаны амралт авсан тул Хяналт–шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Гантөмөрийг 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.


3. Б.Гантөмөрт сар бүр үндсэн цалингаас 40 хувийн нэмэгдэл тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны
өдрийн Б/27 дугаар тушаалын хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганболд - Төрийн захиргааны удирдлагын

хэлтсийн дарга

Гишүүд: Б.Энхбаатар -Төрийн захиргааны удирдлагын

хэлтсийн мэргэжилтэн

Х.Болормаа -Санхүү, аж ахуйн тасгийн нярав

-оОо-